

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/24/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:  
[www.audit.mn](http://www.audit.mn)

Улаангом хот  
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,  
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь  
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn  
Аудитын менежер: М.Бат-Амгалан  
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn  
Ахлах аудитор: Б.Авирмэд  
Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,  
Ө.Бадрахын гудамж  
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,  
E-mail: uvs@audit.gov.mn

БӨХМӨРӨН СУМЫН ЗАСАГ  
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА  
Н.БАТТУЛГА ТАНАА

᠒᠐᠒᠒.᠐᠒.᠒5 № УВА-᠒᠐᠒᠒/᠒᠕/᠕᠕ -᠐᠕᠒᠒᠑  
танай -ны № -т

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.БАТСУУРЬ

0200200172

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт.....	2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .....	4
3. Аудитын тайлан .....	6
3.1 Ерөнхий зүйл .....	12
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал .....	12
3.4 Материаллаг байдал.....	13
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	13
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв .....	13
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг .....	14
3.8 Аудитын гол асуудал.....	14
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	14
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	15
4. Аудитын илрүүлэлт.....	15
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл .....	16

## Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС

Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>23,249,941.00</u></b>	<b><u>35,075,024.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	1,125,000.00	177,533.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	52,533.00
<b>335</b>	<b>Бусад авлага</b>	1,125,000.00	125,000.00
3351	Байгууллагаас авах авлага	1,000,000.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	125,000.00	125,000.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	22,124,941.00	34,897,491.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	22,124,941.00	34,897,491.00
35410	Бичиг хэргийн материал	2,338,200.00	2,366,450.00
35420	Аж ахуйн материал	19,216,741.00	31,961,041.00
35470	Бусад хангамжийн материал	570,000.00	570,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>2,389,284,504.03</u></b>	<b><u>2,425,309,297.13</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	2,389,284,504.03	2,425,309,297.13
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	2,356,423,170.40	2,394,107,963.46
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,212,680,966.00	2,322,385,451.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-357,618,513.46	-440,690,107.39
39203	Авто-тээврийн хэрэгсэл	161,843,000.00	273,983,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-100,909,278.02	-135,464,958.26
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	284,083,050.00	288,595,470.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-108,866,587.12	-139,543,049.05
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	75,163,744.77	70,785,699.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-25,238,918.48	-25,087,148.27
39209	Зам, гүүрийн байгууламж	230,525,424.00	230,525,424.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-35,460,364.33	-69,776,140.45
39214	Бусад үндсэн хөрөнгө	30,911,817.20	30,911,817.20
39215	Хуримтлагдсан элэгдэл	-10,691,170.16	-12,517,494.32
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	32,861,333.63	31,201,333.67
39301	Програм хангамж	1,905,000.00	1,905,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,615,000.00	-1,675,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	44,438,000.00	44,438,000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-11,866,666.37	-13,466,666.33
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>2,412,534,445.03</u></b>	<b><u>2,460,384,321.13</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>607,200.00</u></b>	<b><u>607,200.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	607,200.00	607,200.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	607,200.00	607,200.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	607,200.00	607,200.00
41361	Байгууллагад төлөх өглөг	607,200.00	607,200.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>2,411,927,245.03</u></b>	<b><u>2,459,777,121.13</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	2,411,927,245.03	2,459,777,121.13
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	747,406,472.99	747,406,472.99
51101	Өмч: - төрийн	747,406,472.99	747,406,472.99

512	Хуримтлагдсан үр дүн	1,488,067,515.77	1,535,996,490.87
51210	Өмнөх үеийн үр дүн	1,488,067,515.77	1,488,146,614.77
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	47,849,876.10
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	176,453,256.27	176,374,157.27
6	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b> VI=IV+V	<b><u>2,412,534,445.03</u></b>	<b><u>2,460,384,321.13</u></b>

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>664,046,443.00</b>	<b>644,477,809.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>132,414,376.00</b>	<b>198,335,005.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	132,414,376.00	198,335,005.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	132,414,376.00	198,335,005.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	132,414,376.00	198,335,005.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>531,632,067.00</b>	<b>446,142,804.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	78,649,867.00	34,994,704.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,504,000.00	3,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,145,867.00	31,294,704.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	452,982,200.00	411,148,100.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	452,982,200.00	411,148,100.00
2	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>613,498,352.67</b>	<b>596,308,552.90</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>598,498,352.67</b>	<b>596,308,552.90</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	539,746,119.68	564,797,822.47
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	240,030,198.00	239,358,006.00
210101	Үндсэн цалин	202,912,915.00	202,248,103.00
210105	Гэрээт ажлын хөлс	37,117,283.00	37,109,903.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	30,084,659.01	31,080,915.57
210201	Тэтгэврийн даатгал	20,482,912.33	21,480,442.37
210202	Тэтгэмжийн даатгал	2,403,482.67	2,394,803.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,922,647.87	1,919,272.21
210204	Ажилгүйдлийн даатгал	479,665.80	479,817.84
210205	Эрүүл мэндийн даатгал	4,795,950.34	4,806,580.10
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	29,329,563.00	33,349,942.00
210301	Гэрэл, цахилгаан	5,854,443.00	7,765,622.00
210302	Түлш, халаалт	23,475,120.00	25,584,320.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	31,923,688.00	38,095,834.00
210401	Бичиг хэрэг	3,321,650.00	3,376,650.00
210402	Тээвэр, шатахуун	21,669,698.00	26,844,554.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,688,340.00	5,055,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	550,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,694,000.00	2,419,530.00
2105	<b>Нормативт зардал</b>	00.00	700,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	700,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	11,402,600.00	5,732,300.00
210604	Урсгал засвар	11,402,600.00	5,732,300.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	3,177,000.00	3,500,000.00
210702	Дотоод албан томилолт	3,177,000.00	3,500,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,760,460.00</b>	<b>1,604,331.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	602,053.00	283,410.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,475.00	150,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,646.00	176,746.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	370,000.00	418,000.00
210807	Газрын төлбөр	203,286.00	172,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>192,037,951.67</b>	<b>211,376,493.90</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	28,596,850.00	25,678,762.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,000,000.00	00.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	158,441,101.67	185,697,731.90
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>58,752,232.99</b>	<b>31,510,730.43</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>38,707,800.00</b>	<b>12,478,400.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	11,653,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,875,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	832,000.00	825,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>20,044,432.99</b>	<b>19,032,330.43</b>
213304	Хөрөнгийн	20,044,432.99	19,032,330.43
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>15,000,000.00</b>	<b>00.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>15,000,000.00</b>	<b>00.00</b>
223001	Бусад хөрөнгө	15,000,000.00	00.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>50,548,090.33</b>	<b>48,169,256.10</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>22,351,702.83</b>	<b>319,380.00</b>
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	9,560,411.96	319,380.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	12,791,290.87	00.00
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	<b>-22,351,702.83</b>	<b>-319,380.00</b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>28,196,387.50</b>	<b>47,849,876.10</b>

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>531,632,067.00</b>	<b>446,142,804.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>531,632,067.00</b>	<b>446,142,804.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	78,649,867.00	34,994,704.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	2,504,000.00	3,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	76,145,867.00	31,294,704.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>452,982,200.00</b>	<b>411,148,100.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	452,982,200.00	411,148,100.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>468,018,901.00</b>	<b>416,142,804.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>468,018,901.00</b>	<b>416,142,804.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>409,098,668.01</b>	<b>384,632,073.57</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	240,030,198.00	239,358,006.00
210101	Үндсэн цалин	202,912,913.00	202,248,103.00
210105	Гэрээт ажлын хөлс	37,117,285.00	37,109,903.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>30,084,659.01</b>	<b>31,133,448.57</b>
210201	Тэтгэврийн даатгал	20,482,912.33	21,528,688.37
210202	Тэтгэмжийн даатгал	2,403,482.67	2,399,090.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,922,647.87	1,919,272.21
210204	Ажилгүйдлийн даатгал	479,665.80	479,817.84
210205	Эрүүл мэндийн даатгал	4,795,950.34	4,806,580.10
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>29,329,563.00</b>	<b>33,349,942.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	5,854,443.00	7,765,622.00
210302	Түлш, халаалт	23,475,120.00	25,584,320.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>35,985,038.00</b>	<b>40,711,284.00</b>
210401	Бичиг хэрэг	3,358,650.00	3,376,650.00
210402	Тээвэр, шатахуун	21,129,698.00	26,907,554.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,688,340.00	5,035,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	950,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	5,858,350.00	4,991,980.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	<b>432,000.00</b>	<b>1,160,000.00</b>
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	00.00	700,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	432,000.00	460,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>29,579,300.00</b>	<b>8,732,300.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	450,000.00	00.00
210602	Тавилга	16,949,800.00	00.00
210604	Урсгал засвар	12,179,500.00	8,732,300.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>2,777,000.00</b>	<b>3,500,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	2,777,000.00	3,500,000.00

<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	1,760,460.00	1,604,331.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	602,053.00	283,410.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	160,000.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,475.00	150,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	191,646.00	176,746.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	33,000.00	00.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	370,000.00	418,000.00
210807	Газрын төлбөр	203,286.00	172,000.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	39,120,450.00	25,082,762.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	33,720,450.00	25,082,762.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,400,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>58,920,232.99</b>	<b>31,510,730.43</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	38,875,800.00	12,478,400.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	00.00	11,653,400.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	37,875,800.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	825,000.00
<b>2133</b>	<b>Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	20,044,432.99	19,032,330.43
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b>63,613,166.00</b>	<b>30,000,000.00</b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b>63,613,166.00</b>	<b>30,000,000.00</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>63,613,166.00</b>	<b>30,000,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	63,613,166.00	30,000,000.00
223001	Бусад хөрөнгө	63,613,166.00	30,000,000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b>-63,613,166.00</b>	<b>-30,000,000.00</b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	00.00	00.00
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	00.00	00.00
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	00.00	00.00

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>718,968,472.99</b>	<b>74,121,063.00</b>	<b>157,638,961.84</b>	<b>950,728,497.83</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	1,874,823.00	1,874,823.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>718,968,472.99</b>	<b>74,121,063.00</b>	<b>159,513,784.84</b>	<b>952,603,320.83</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	20,000,000.00	00.00	33,646,742.22	53,646,742.22
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>747,406,472.99</b>	<b>176,453,256.27</b>	<b>1,488,067,515.77</b>	<b>2,411,927,245.03</b>
<b>2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл</b>	<b>747,406,472.99</b>	<b>176,453,256.27</b>	<b>1,488,067,515.77</b>	<b>2,411,927,245.03</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	79,099.00	79,099.00
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>747,406,472.99</b>	<b>176,453,256.27</b>	<b>1,488,146,614.77</b>	<b>2,412,006,344.03</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	-79,099.00	00.00	-79,099.00
Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00
Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	47,849,876.10	47,849,876.10
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>747,406,472.99</b>	<b>176,374,157.27</b>	<b>1,535,996,490.87</b>	<b>2,459,777,121.13</b>

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>407,148,100.00</b>	<b>392,115,769.57</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>407,148,100.00</b>	<b>392,115,769.57</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>394,661,700.00</b>	<b>379,637,369.57</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>240,498,300.00</b>	<b>239,358,006.00</b>
210101	Үндсэн цалин	203,376,100.00	202,248,103.00
210105	Гэрээт ажлын хөлс	37,122,200.00	37,109,903.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>32,467,200.00</b>	<b>31,133,448.57</b>
210201	Тэтгэврийн даатгал	22,847,300.00	21,528,688.37
210202	Тэтгэмжийн даатгал	2,405,000.00	2,399,090.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,923,900.00	1,919,272.21
210204	Ажилгүйдлийн даатгал	481,000.00	479,817.84
210205	Эрүүл мэндийн даатгал	4,810,000.00	4,806,580.10
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>40,237,900.00</b>	<b>33,349,942.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	6,500,000.00	7,765,622.00
210302	Түлш, халаалт	33,737,900.00	25,584,320.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>40,681,500.00</b>	<b>40,449,990.00</b>
210401	Бичиг хэрэг	3,411,800.00	3,376,650.00
210402	Тээвэр, шатахуун	25,715,000.00	26,646,260.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,227,300.00	5,035,100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	400,000.00	400,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,927,400.00	4,991,980.00
2105	<b>Нормативт зардал</b>	<b>635,200.00</b>	<b>460,000.00</b>
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	635,200.00	460,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>8,838,200.00</b>	<b>8,732,300.00</b>
210604	Урсгал засвар	8,838,200.00	8,732,300.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>7,142,500.00</b>	<b>3,500,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	7,142,500.00	3,500,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,920,200.00</b>	<b>1,320,921.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	250,000.00	0.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	403,200.00	403,200.00
210803	Даатгалын үйлчилгээ	265,000.00	150,975.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	280,000.00	176,746.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	100,000.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	450,000.00	418,000.00
210807	Газрын төлбөр	172,000.00	172,000.00
2109	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>22,240,700.00</b>	<b>21,332,762.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	21,824,200.00	21,332,762.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	416,500.00	0.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>12,486,400.00</b>	<b>12,478,400.00</b>
2132	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>12,486,400.00</b>	<b>12,478,400.00</b>
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	11,653,400.00	11,653,400.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	833,000.00	825,000.00
III	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>407,148,100.00</b>	<b>392,115,769.57</b>

<b>32</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>407,148,100.00</b>	<b>392,115,769.57</b>
320001	Орон нутгийн төсвөөс	407,148,100.00	392,115,769.57
<b>6</b>	<b>ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ</b>	<b>49.00</b>	<b>49.00</b>
<b>61</b>	<b>БАЙГУУЛЛАГЫН ТОО</b>	<b>1.00</b>	<b>1.00</b>
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>24.00</b>	<b>24.00</b>
620001	Удирдах ажилтан	6.00	6.00
620002	Гүйцэтгэх ажилтан	9.00	9.00
620003	Үйлчлэх ажилтан	3.00	3.00
620004	Гэрээт ажилтан	6.00	6.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>24.00</b>	<b>24.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	9.00	9.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	8.00	8.00
650010	Гэрээт ажилтан	2.00	2.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	5.00	5.00

**2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН**

*/төгрөгөөр/*

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>4,994,704.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>4,994,704.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	4,994,704.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	261,294.00
210402	Тээвэр, шатахуун	261,294.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	700,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	700,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	283,410.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	283,410.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,750,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,750,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>30,000,000.00</b>
2200	Дотоод эх үүсвэрээр	30,000,000.00
223001	Бусад хөрөнгө	30,000,000.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	34994704.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	34,994,704.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	3,700,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	31,294,704.00
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### **3. Аудитын тайлан**

#### **3.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 01 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

#### **3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт**

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь иргэдэд төрийн үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 4.9 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 596.3 сая төгрөгийн 1 хувь буюу 6.0 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 4.8 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бөхмөрөн сумын засаг даргын тамгын газар 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 47,849.9 мянган төгрөгөөр буюу 2 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	1,125.0	177.5	-947.5
Урьдчилгаа	0	0	0
Бараа материал	22,124.9	34,897.5	12,772.6
Үндсэн хөрөнгө	2,389,284.5	2,425,309.3	36,024.8
<b>Нийт хөрөнгө</b>	<b>2,412,534.4</b>	<b>2,460,384.3</b>	<b>47,849.9</b>
Өр төлбөр	607.2	607.2	0
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,411,927.2	2,459,777.1	47,849.9
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>2,412,534.4</b>	<b>2,460,384.3</b>	<b>47,849.9</b>

Бараа материалын дансны үлдэгдэл 34,897.5 мянган төгрөг болж 12,772.6 мянган төгрөгөөр өссөн нь аж ахуй материал дээр өвс тэжээлийн нөөц нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,425,309.3 мянган төгрөг болж 36,024.8 мянган төгрөгөөр өссөн нь урсгал төсвийн худалдан авалтаар 34,000.0 мянга, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 195,356.9 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалсан байна. Үндсэн хөрөнгөөс акталж устгасан 7,378.0 мянган төгрөгийн хөрөнгө хасагдсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,459,777.1 мянган төгрөг болж 47,849.9 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн нэмэгдсэнээс шалтгаалжээ.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос -19,268.6 мянган төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна.

Нийт зардал өмнөх оноос 17,498.1 мянган төгрөгөөр буюу 2 хувиар буурсан байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

### **3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### **3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 442,194.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 442,194.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 35,046.3 мянган төгрөгөөр бууруулж 407,148.1 мянган төгрөгөөр баталсан байна.

#### **3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 407,148.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 407,148.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс үлдэгдлээс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 411,148.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 392,115.7 мянган төгрөгийг зарцуулж 19,032.3 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 392,115.7 мянган төгрөг буюу 96.3 хувьтай байгаа нь зардлыг 15,032.3 мянган төгрөгөөр хэмнэж, илүү олгосон санхүүжилт 4,000.0 мянган төгрөгийг зарцуулахгүйгээр төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

#### **3.6.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дээд шатны төсвийн захирагчаас 31,294.7 мянга, төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс ирсэн хандив 700.0 мянга, нийт 34,994.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

### **3.8 Аудитын гол асуудал**

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газрын хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 131, хугацаа хоцроож 18 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

#### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

#### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 855.0 мянган төгрөгийн 2 алдаа зөрчил илэрснээс 855.0 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 1 зөвлөмж өглөө.

#### 4.3 Албан шаардлага

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх заалтад “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.3-т “төрийн болон орон нутгийн өмчит, тэдгээрийн оролцоотой аж ахуйн нэгж, байгууллагын дотоод зохион байгуулалтын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, орон тоо, чиг үүргийн давхардлыг арилгаж, төсөв, зардлыг хэмнэсэн байхаар шинэчлэх, удирдлагын цалин хөлсийг орлого, үр ашигтай нь уялдуулан, үйл ажиллагааны чиглэл, цар хүрээ, түвшин зэргийг харгалзан нэг хэлбэр, нийтлэг жишгээр ангилан тогтоодог зарчимд шилжих, цалин хөлсийг нэмэгдүүлэхгүй, шагнал, урамшуулал олгохгүй байх, зочин төлөөлөгч хүлээн авах, бэлэг дурсгал (цүнх, календарь, мэндчилгээ г.м)-ын зардлыг гаргахгүй байх” гэж заасныг зөрчин 855.0 мянган төгрөгийг бэлэг дурсгалын зүйлд зарцуулсан алдаа зөрчилд албан шаардлага өглөө.

#### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

##### 1. **Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

###### 1.1. Илрүүлэлт:

Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар нь ажилтнуудад ур чадварын нэмэгдэл олгох шийдвэр гаргахдаа хүчингүй болсон Засгийн газрын 1995 оны 96 дугаар тогтоолыг үндэслэсэн байна.

###### 1.2. Өгсөн зөвлөмж:

Цаашид Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолыг мөрдөж ажиллах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

#### 5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл


/мянган.төгрөгөөр/

№	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Бөхмөрөн сумын Засаг даргын тамгын газар	2	855.0					1	855.0	1	0.0
<b>НИЙТ</b>		<b>2</b>	<b>855.0</b>					<b>1</b>	<b>855.0</b>	<b>1</b>	<b>0.0</b>

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

#### АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТ-ОЧИР/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /Б.АВИРМЭД/

2022 оны 02 сарын 15-ны өдөр